

**ХЭНТИЙ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
2024 ОНЫ ДЭЭД ГАЗРЫН ТОГТООЛ ШИЙДВЭР,
ЭРХ ЗҮЙН АКТЫН ХЭРЭГЖИЛТ**

2024.12.15

Чингис хот

№	Эрхзүйн актын нэр, огноо, дугаар, заалт	Хэрэгжилтийн явц, гарсан үр нөлөө, холбогдох эрх зүйн актын дагуу хийсэн шинэлэг ажлууд	Тайлбар, хэрэгжилтийн үнэлгээ
А	1	2	3
Нэг. Засгийн газрын тогтоол			
1	<p>Монгол Улсын Засгийн газрын тогтоол 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 438 дугаар тогтоол Даатгуулагчийн тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэмж олгох журмын тухай 2024/03/06 04/460</p>	<p>Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд заасан нөхцөл хангасан даатгуулагчид тэтгэмж тогтоож олгож байгаа бөгөөд эрүүл мэндийн байгууллагаас цахимаар бичиж илгээсэн эмнэлгийн хуудсыг ажил олгогч, даатгуулагч хүлээн авч тэтгэмж авах хүсэлтээ эмнэлгийн хуудас авснаас хойш 4 долоо хоногийн дотор баталгаажуулж нийгмийн даатгалын байгууллагад илгээснээр магадлагч эмч, тэтгэмжийн байцаагч, хяналт шалгалтын байцаагчаар баталгаажуулан Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 438 дугаар тогтоол “Даатгуулагчийн тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэмж олгох журам”-ын дагуу баримт бичгийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шийдвэрлэж, ажил олгогч, даатгуулагчийн банкин дахь дансаар дамжуулан олгож байна. Ажилгүйдлийн тэтгэмжийг цаасаар болон цахимаар ажил олгогчийн тушаал шийдвэр гарснаас хойш 28 хоногийн дотор хүлээн авч тэтгэмж олгох даатгуулагчийн жагсаалтыг хяналт шалгалтын байцаагчаар хянуулан харьяалах нэгж хэлтэс, газрын даргаар баталгаажуулан хуваарийн дагуу тухай бүр тэтгэмж олгох жагсаалтыг сангийн нягтлан бодогчид хүргүүлэн олгож, даатгуулагчид олгосон тэтгэмжийг ажилгүйдлийн тэтгэмжийн хувийн хэрэгт тэмдэглэгээ хийн бүртгэж байна. Мөн тэтгэмж авч байх хугацаандаа ажилд орсон 9 даатгуулагчтай холбоотой тэтгэмжийг зогсоож тухайн даатгуулагчтай тооцоо нийлэн илүү олгосон ажилгүйдлийн тэтгэмжийг тэтгэмжийн даатгалын санд буцаан төлүүлэх арга хэмжээ авч ажилласан. Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 970 даатгуулагчид 728201.9 мянган төгрөг, жирэмсэн болон амаржсаны тэтгэмж 910 даатгуулагчид 3170552.3 мянган төгрөг, Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж 333 хүнд</p>	

		666000.0 мянган төгрөг, ажилгүйдлийн тэтгэмж 573 даатгуулагчид 1639252.1 мянган төгрөгийн тэтгэмжийг тус тус олгосон байна.	
2	Монгол Улсын Засгийн газрын тогтоол 2023 оны дугаар сарын 27-ны өдрийн 469 дугаар тогтоол Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм, Нийгмийн даатгалын улсын байцаагчийн дүрмийн тухай 2024/03/06 04/460	Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 469 дугаар тогтоолоор батлагдсан “Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм”, “Нийгмийн даатгалын улсын байцаагчийн дүрэм”-ийг газрын албан хаагчдад танилцуулан, сумдын байцаагчдад албан бичгээр хүргүүлэн өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.	
3	Монгол Улсын Засгийн газрын тогтоол 2023 оны 11 дугаар сарын 29-ний өдрийн 422 дугаар тогтоол ҮОМШӨ-ний даатгалын сангийн даатгуулагч, эрүүл мэндийн нөхөн сэргэлтийн зардлын төлбөр авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон төлбөрийг олгох санхүүжүүлэх журмын тухай 2024/01/10 01/82	Тус газар нь тайлант хугацаанд Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас 52 хүнд 6226.4 мянган төгрөгийн сувиллын болон унааны зардал олгосон. Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 422 дугаар тогтоол “ҮОМШӨ-ний даатгалын сангийн даатгуулагч, эрүүл мэндийн нөхөн сэргэлтийн зардлын төлбөр авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон төлбөрийг олгох санхүүжүүлэх журам”-д заасан зардлын төлбөр авахад бүрдүүлэх баримт бичгийн дагуу материалыг 28 хоногийн дотор хүлээн авч магадлагч эмчээр баталгаажуулан олгосон байна. Мөн тухайн онд үйлдвэрлэлийн ослын сэргээн засах сувиллын тусламж үйлчилгээний болон протез, ортопедийн зардал төлбөр гараагүй болно.	
4	Монгол Улсын Засгийн газрын тогтоол 2023 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 439 дугаар тогтоол ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж тогтоолгоход бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэвэр тэтгэмж олгох журам 2024/01/10 01/82	Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагчийн материалыг эрүүл мэндийн байгууллагаас олгосон эмнэлгийн хуудасыг үндэслэн ажил олгогч тэтгэмж авах хүсэлтээ баталгаажуулан нийгмийн даатгалын байгууллагад илгээснээр тэтгэмжийн байцаагч цахимаар хүлээн авч засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 439 дүгээр тогтоол “ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж тогтоолгоход бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэвэр тэтгэмж олгох журам”, НДЕГ-ын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01/82 тоот зөвлөмжийн дагуу тэтгэмжийг тогтоон олгож тус сангаас 30 даатгуулагчид хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг хуульд заасан болзол журмын дагуу хүлээн авч хяналтын байцаагчаар баталгаажуулж 73449.5 мянган төгрөгийн тэтгэмж олгосон байна. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 439 дугаар тогтоол “ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж тогтоолгоход бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэвэр, тэтгэмж олгох журам”-ыг дагуу 2024 онд тус сангаас давхардсан тоогоор 4638 хүнд 4.36715 мянган төгрөгийн тэтгэвэр олгогдоод байна.	

5	<p>Монгол Улсын Засгийн газрын тогтоол 2023 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 440 дугаар тогтоол Тогтоол хүчингүй болгох тухай 2024/01/10 01/82</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 440 дугаар тогтоолоор “Ажилгүйдлийн даатгалын сангаас сургалтад хамрагдах нэг даатгуулагчид олгох зардлын дээд хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 361 дүгээр тогтоол хүчингүй болсон.Уг тогтоолыг нийгмийн даатгалын газрын нийт байцаагч, албан хаагчдад танилцуулан хэрэгжилтийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөн ажиллаж байна.</p>	
6	<p>Монгол Улсын Засгийн газрын тогтоол 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 450 дугаар тогтоол Тэтгэвэр тогтоолгох, тэтгэврийн хэмжээг өөрчлөхөд бүрдүүлэх баримт бичиг, тэтгэвэр олгох журам 2024/01/10 01/82</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 450 дугаар тогтоолоор батлагдсан “Тэтгэвэр тогтоолгох, тэтгэврийн хэмжээг өөрчлөхөд бүрдүүлэх баримт бичиг, тэтгэвэр олгох журам”-ын дагуу 2024 онд шинээр 688 тэтгэвэр тогтоогдсон байна. Үүнээс өндөр насны 491, хөдөлмөрийн чадвар алдсаны 131, тэжээгчээ алдсаны 66 тэтгэвэр тогтоогдон хэвийн олгогдож байна.Мөн уг журмын хэрэгжилтийг ханган ажиллах, иргэд даатгуулагчид хүргэх, сурталчлах ажлыг зохион байгуулахыг нийт байцаагч ажилчдад үүрэг болгон ажилласан.</p>	
7	<p>Монгол Улсын Засгийн газрын тогтоол 2024 оны 01 дугаар сарын 10-ны өдрийн 10 дугаар тогтоол Итгэлцүүр тогтоох тухай 2024/02/01 04/243</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 10 дугаар тогтоолын дагуу тус газар нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Цэргийн алба хаасны тэтгэвэр , тэтгэмжийн хуульд заасны дагуу даатгуулагч 2024 онд тэтгэвэр тогтооход мөрдөх цалингийн итгэлцүүрийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлэн ажиллаж байна.</p>	
8	<p>Монгол Улсын Засгийн газрын тогтоол 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 109 дугаар тогтоол Ёс зүйн хэм хэмжээ батлах тухай 2024/10/17 03/2139</p>	<p>Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газар нь нийт байцаагч, ажилтнууд өдөр тутмын үйл ажиллагаандаа баримтлах төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах хүрээнд ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх чиг үүргийг хэрэгжүүлэх ёс зүйн дэд хороог ажиллуулдаг. Тус дэд хороо нь 5 гишүүнтэй ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолоор батлагдсан "ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ"-ыг мөрдлөг болгон ажиллаж байна. 2024 оны 10 дугаар сарын 24, 25-ны өдрүүдэд зохион байгуулсан байцаагч ажилчдын нэгдсэн сургалтаар "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг" танилцуулан нийт байцаагч, ажилчдаар гарын үсэг зуруулан баталгаажуулж хувийн хэрэгт хавсаргасан. Байцаагч ажилчдыг соён гэгээрүүлэх ажлын хүрээнд сар бүр сургалт хүмүүжлийн ажил зохион байгуулж байна.</p>	

9	Монгол Улсын Засгийн газрын тогтоол 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 75 дугаар тогтоол Аргачлал батлах тухай 2024/10/18 01/2153	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 75 дугаар тогтоолоор батлагдсан “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх аргачлал”-ыг Нийгмийн даатгалын газрын нийт байцаагч ажилчдад танилцуулан нийгмийн даатгалын сангаас олгох бүх төрлийн тэтгэврийг 2025 оны 01 дүгээр сарын 01-өдрөөс эхлэн нэмэгдүүлэн үнэн зөв хэрэгжүүлэн ажиллах чиглэл өгсөн.	
Хоёр. Монгол улсын хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал			
1	Монгол улсын хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/20 дугаар тушаал Нийгмийн даатгалын багц хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан хуулиар тусгайлан олгосон заалт хүчингүй болсон тухай 2024/03/06 04/460	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 02 дугаар сарын 07- ны өдрийн А/20 дугаар тушаалаар Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2018 оны “Дүрэм батлах тухай” А/77 дугаар тушаалын хавсралт “Даатгуулагчийн малчнаар ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох зөвлөлийн дүрэм” –ийг хүчингүй болгосон тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж аймаг, сумын ЗДТГазрын дэргэдэх “Даатгуулагчийг малчнаар ажиллах нийгмийн даатгал төлсөн хугацааг тодорхойлох орон тооны бус зөвлөл” хууль эрх зүйн зохицуулалтгүй болж татан буугдсан шийдвэрийг иргэд даатгуулагч, малчдад хүргэн хэрэгжилтийг ханган ажилласан.	
2	Монгол улсын хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/40 дугаар тушаал Нийгмийн даатгалын улсын байцаагчийн шалгалтын журмын тухай 2024/03/20 04/559	Нийгмийн даатгалын улсын байцаагчийн шалгалтын журмыг хүлээн авч тус газрын албан хаагчдад танилцуулж, сумдын байцаагчдад албан бичгээр хүргүүлсэн.Мөн журмын дагуу 2024 оны улсын байцаагчийн эрх шинээр олгох, баталгаажуулах, сэргээх, цуцлах шалгалтад шалгалт өгөх нөхцөл, шалгуур, болзол хангасан 6 албан хаагч хамрагдан 3-н албан хаагч улсын байцаагчийн эрхээ амжилттай баталгаажуулсан.	
3	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, сангийн сайдын хамтарсан тушаал 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/44, А/40 дугаар тушаал Маягтын загвар, аргачлал батлах тухай 2024/03/29 04/639	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, сангийн сайдын хамтарсан 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/44, А/40 дугаар тушаалаар батлагдсан 18 төрлийн маягыг Нийгмийн даатгалын газрын өдөр тутмын үйл ажиллагаанд аргачлалын дагуу хэрэглэж хэвшээд байна.Мөн батлагдсан маягт, аргачлалыг тус газрын байцаагч, нягтлан бодогч нарт тусгайлан 7 хоног бүрийн дотоодын сургалтын цаг дээр танилцуулан ажилласан.	
4	Монгол улсын хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/202 дугаар тушаал Журам батлах тухай 2024/04/04 04/702	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 25- ны өдрийн А/202 дугаар тушаалаар батлагдсан “Итгэлцүүр хэрэглэх журам”-ыг сумдын болон төвийн байцаагч, ажилчдад танилцуулж, дээрх журмыг хэрэглэх албан хаагч тус бүрийн албаны мэйлээр хүргүүлэн мэргэжил, арга зүйгээр ханган ажиллаж байна.	

5	<p>Монгол улсын хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал 2024 оны 03 дугаар сарын 22-нй өдрийн А/53 дугаар тушаал</p> <p>Дотоод аудитын тайлан батлах, ажил эрчимжүүлэх тухай 2024/04/16 03/785</p>	<p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн “Дотоод аудитын тайлан батлах, ажил эрчимжүүлэх тухай” А/53 дугаар тушаалын хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдөр баталсан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийх удирдамжийн дагуу Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь 2024 оны 01 дүгээр сарын 03-05-ны өдрийн хооронд дотоод аудитын ажлыг зохион байгуулсан. Уг ажлын хүрээнд шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, шилэн дансны цахим хуудасны 2023 оны хөтлөлт, тайлан мэдээ байршуулсан байдал, холбогдох шийдвэрийн хуулбар, баримт бичгийг оруулсан эсэхэд үнэлгээ өгч, гарсан зөрчлийг давтан гаргахгүй байх чиглэл өгч ажилласан. Шилэн дансны мэдээллийг цахим системд тухай бүр, хуулийн хугацаанд тайлагнаж байгаа бөгөөд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 139 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 138, хугацаа хоцроосон 1 мэдээ байна. Нийгмийн даатгалын сантай холбоотой 130 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 124, хугацаа хоцроосон 6 мэдээ байна. Энэ нь 1-дүгээр улирлаар 2 мэдээлэл буруу оруулснаас болж засварлах үйлдэл хийсэн тул хугацаа хоцорсон байна. Мөн 3 дугаар улирлын байдлаар хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй боловч нийгмийн даатгалын сангийн 5 саяас дээш дүнтэй орлого, зарлагын гүйлгээг дутуу оруулсан зөрчил гарсныг тухай бүр залруулан ажилласан. 2024 онд НДЕГ-аас ирүүлсэн чиглэл, “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ийн дагуу шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, мэдээллийн үнэн зөв, бүрэн байршуулсан эсэхэд улирал бүр хяналт тавих ажлыг Санхүү бүртгэл, хамралт, орлогын хэлтэстэй хамтран хийж гүйцэтгэж байна.</p>	
6	<p>Улсын Ерөнхий прокурор хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан тушаал 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/42, А/73 дугаар тушаал</p> <p>Эрх бүхий албан тушаалтнаас, оногдуулсан торгох, шийтгэлийг нэмэгдүүлж тооцох хугацаа, аргачлалын тухай 2024/05/10 06/982</p>	<p>Нийгмийн даатгалын газар нь Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу тус газарт ирсэн гомдол мэдээллийг шалган тус хуульд заасан зүйл заалтын дагуу холбогдох арга хэмжээг авч зөрчилд хамаарах баримт материалыг прокурорын газраар хянуулан төлүүлэхээр шийдвэрлэсэн торгууль, шимтгэл, алдангийг тухай бүр барагдуулах ажлыг зохион байгуулан хуулийн хэрэгжилтийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон, ханган ажилладаг. 2024 оны байдлаар Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу шийдвэрлэгдэх 1 байгууллагын гомдол мэдээлэл бүртгэгдсэн. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 13-07/04 тоот удирдамжийн хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын, Хяналт шалгалтын газрын нийгмийн хамгааллын улсын байцаагч О.Пүрэвжав, Б.Хишигжаргал нарын хийсэн төлөвлөгөөт</p>	

		<p>хяналт шалгалтаар 4201639 тоот регистрийн дугаартай Хэнтий аймгийн “ЗЭЭТ ХҮЧ” ХХК-ны үйл ажиллагаанд хийсэн төлөвлөгөөт хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн материалыг шилжүүлэн ирүүлснийг хянан үзээд, тус компани нь 2020 онд үүсгэн байгуулагдсанаас хойш нийгмийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулан ажилчдыг нийгмийн даатгалд хамруулалгүй нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөс зайлсхийх гэх “ЗЭЭТ ХҮЧ” ХХК-д холбогдох 0362-01 дугаартай зөрчилд Монгол Улсын Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 3.1, 4.8 дугаар зүйлүүдийг тус тус удирдлага болгон холбогдогчоос мэдүүлэг авч, хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, тухайн ажил олгогчийг Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, төлбөр зөрчлийг барагдуулан ажилласан.</p>	
7	<p>Монгол улсын хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал 2024 оны 04 дугаар сарын 23-ны өдрийн А/87 дугаар тушаал Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2024/05/30 04/1125</p>	<p>Монгол улсын хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 04 дугаар сарын 23-ны өдрийн А/87 дугаар тушаалаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны “Жагсаалт, журам батлах тухай” А/221 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Тэтгэврийг хөнгөлөлтэй тогтоох газрын доор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт”-д нэмэлт, өөрчлөлт оруулсан шийдвэрийг албан хаагчдад танилцуулан, арга зүйн зөвлөгөө өгч тушаал, шийдвэрийг сумдын байцаагчдад хүргүүлэн ажилласан.</p>	
8	<p>Монгол улсын хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн А/39 дугаар тушаал Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны нэгдсэн удирдамж, зардлын жишиг хэмжээг батлах тухай 2024/05/31 01/1136</p>	<p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэх нэгдсэн удирдамжийн дагуу тус газар нь Хэнтий аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газартай хамтран ажиллаж Од сар санхүү, Дриймкек ХХК гэсэн аж ахуй нэгж байгууллагуудтай нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тооцоо нийлж, баталгаажуулан Нийгмийн даатгалын хуулийн талаар мэдээлэл зөвлөгөө өгсөн.Цахим сангаас шимтгэл төлөлтийн тодорхойлолт авч хамтран ажилласан байна. Мөн нийгмийн даатгалын газрын байцаагч ажилчдад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны нэгдсэн удирдамж, зардлын жишиг хэмжээг танилцуулсан болно.</p>	
9	<p>Эрүүл мэндийн сайд хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаал 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/441, А/192 дугаар тушаал Даатгуулагч, Хүний ХЧА хувь, хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөрлөх зохицуулалт хийхэд баримтлах өвчний жагсаалт батлах тухай 2023/12/28</p>	<p>2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/441, А/192 дугаар тушаалаар батлагдсан “Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөрлөх зохицуулалт хийхэд баримтлах өвчний жагсаалт” баталсантай холбогдуулан эрүүл мэндийн магадлаын төв зөвлөлөөс 2024 онд даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний жагсаалтын дагуу мэргэжлийн багаас бүрдсэн эмч нарын сургалтыг цахимаар 6 удаа хийж сургалтад Хэнтий аймгийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн 5 эмч, 3</p>	

	02/6624	мэргэжилтэн 6 удаа хамрагдсан. Эрүүл мэндийн газартай хамтарч 15 сумын 40 эмч мэргэжилтнүүдэд сургалтыг зохион байгуулсан.	
10	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаал 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/177, А/433 дугаар тушаал Журам маягтын загвар батлах тухай 2024/01/10 01/82	2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/177, А/433 дугаар тушаалаар батлагдсан “Журам маягтын загвар батлах тухай” журмын хэрэгжилтийг ханган ажиллах үүднээс Эрүүл мэндийн газартай хамтарч 15 сумын 40 эмч мэргэжилтнүүдэд сургалтыг зохион байгуулсан.	
11	Монгол улсын хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/200 дугаар тушаал Нийгмийн даатгалын сайн дураар, даатгуулахад баримтлах журмын тухай 2024/02/01 04/243	Тус газар нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/200 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу 2024 онд Хэнтий аймгийн хэмжээнд нийт 4986 сайн дурын даатгуулагчтай сайн дурын гэрээ байгуулсан үүнээс малчин, туслах малчны гэрээ 2286, 3 хүртэлх насны хүүхдээ асарч буй эхийн гэрээ 876, эмнэлгийн хяналтад байдаг байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа ажил хөдөлмөр эрхлээгүй эх /эцэг/ 102 тус тус гэрээг хийж баталгаажуулсан.	
12	Монгол улсын хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/37 дугаар тушаал Ажлын хэсэг байгуулах, удирдамж батлах тухай 2024/10/18 03/2164	Ажлын хэсэг байгуулах, удирдамж батлах тухай тушаалын дагуу тус газрын нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх сэргээх, баталгаажуулах албан хаагчдын судалгааг гарган хүргүүлсэн. 2 албан хаагч журмын дагуу шалгалтаас чөлөөлөгдсөн 6 байцаагч шалгалтад хамрагдсанаас 3 албан хаагч шалгалтад тэнцсэн байна.	
Гурав. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол			
1	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01 дүгээр тогтоол Тэтгэвэрийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны эхний /гарааны үлдэгдэл тооцоход баримтлах шимтгэлийн хувь хэмжээ, цалин хөлсний дундаж индекс /итгэлцүүр/ -ийг шинэчлэн батлах тухай 2024/03/05 01	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01 дүгээр тогтоол тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны эхний /гарааны үлдэгдэл тооцоход баримтлах шимтгэлийн хувь хэмжээ, цалин хөлсний дундаж индекс /итгэлцүүр/ -ийг шинэчлэгдсэн тогтоолын хэрэгжилтийг ханган, Нийгмийн даатгалын газрын ажилтан албан хаагч нарт танилцуулан, мэдээ, мэдээллийг гадагшаа чиглэсэн сургалт, өөрийн цахим хуудсаар дамжуулан ажил олгогч, даатгуулагчид хүргэн ажилласан.	
2	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/64 дугаар тогтоол	Нийгмийн даатгалын сангийн авлага барагдуулах чиглэлийг хүлээн авч сумдын байцаагчдад бичгээр хүргүүлсэн. Нийгмийн даатгалын шимтгэлийн 2024 оны авлагын эхний үлдэгдэл 2980.7 сая төгрөг	

	Нийгмийн даатгалын сангийн авлага барагдуулах, ажлыг эрчимжүүлэх тухай 2024/05/13 01/997	байсныг тайлант хугацаанд 2823.6 сая төгрөг буюу 96 хувийг барагдуулан ажилласан. Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг үүссэн хугацаагаар нь ангилж холбогдох журмын дагуу тухай бүр арга хэмжээ авч ажилласнаар урсгал авлага өсгөөгүй. Урьдчилсан байдлаар нийгмийн даатгалын шимтгэлийн оны эцсийн авлагын үлдэгдлийг 850.2 сая төгрөгтэй байхаар тооцож байна.	
Дөрөв. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаал			
1	Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын тушаал 2024 оны 04 дугаар сарын 02-ны өдрийн А/43 дугаар тушаал Даатгуулагчийн төрлийн код нэмж батлах тухай 2024/04/05 04/705	Даатгуулагчийн төрлийн код нэмж батлагдсаныг сумдын байцаагчдад албан бичгээр хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж, нийгмийн даатгалын тайланг хүлээн авч байна. Мөн төсөвт байгууллагын ажил олгогчийн дарга захирал, нягтлан бодогчдын сургалтад мэдээлэл өгсөн.	
2	Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын тушаал 2024 оны 04 дугаар сарын 24-ний өдрийн А/61 дугаар тушаал 2024 оны нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жил болгон зарлах тухай 2024/05/20 04/1054	2024 оныг Нийгмийн даатгалын ерөнхий газраас “Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жил” болгон зарласан. Манай газар нь 2024 онд нийгмийн даатгалд шинээр 89 байгууллагын 286 албан журмын даатгуулагчийг хамруулсан. Мөн 2024 онд шинээр үүссэн хуулийн этгээдийг нийгмийн даатгалд хамруулах чиглэлээр аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Татварын газартай хамтран ажиллаж судалгаа гаргуулан 2 удаагийн чиглэлийг албан бичгээр сумдад хүргүүлэн ажил олгогчийг нийгмийн даатгалд бүртгэн ажилласан байна.	
3	Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын тушаал 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/79 дугаар тушаал Болзолт уралдаан зарлах тухай 2024/05/20 04/1054	“Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх” болзолт уралдааны удирдамжийн дагуу дараах контентуудыг бэлтгэн тус газрын пейж хуудсанд байршуулан иргэд даатгуулагчдад хүргэсэн. Малчин, туслах малчны сайн дурын даатгалын тухай Хэнтий аймгийн Мөрөн сумын Өлзийт багийн малчин Чулуунбаатарын уриалгыг 2024 оны 02 дугаар сарын 27-нд өөрийн цахим хуудсанд байршуулснаар нийт 10.9 мянган хүний хандалт авч, 109 хүн хуваалцан, 53 хүн лайк дарсан байна. https://fb.watch/wftvKqf11f/ Сайн дурын даатгалыг гар утаснаасаа сунгах боломжтой рийл бичлэг бэлтгэн Нийгмийн даатгалын газрын цахим хуудсанд байршуулан иргэд даатгуулагчдад сурталчилснаар нийт 47.0 мянган хүний хандалт авч, 240 хүн хуваалцан, 82 хүн лайк дарсан байна. https://fb.watch/wfrYnDZhlO/ Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, цахим орчинд эерэг байх нөлөөллийн ажлын хүрээнд Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газраас 6 албан хаагч, 3 даатгуулагч иргэн хамруулан "Мэдлэгтэй чихэр" контент, 2024.11.01-нд Талархлын өдөрт зориулан "Бурмаар тэтгэхээр, Урмаар тэтгэ" контент, "Дэм дэмдээ гэдэг нь" рийл, "Зам цэвэр бол автомашинд амгалан, Даатгалаа төлсөн бол амьдралд	

		амгалан" рийл зэргийг бүтээж өөрийн цахим хуудсандаа байршуулсан бөгөөд давхардсан тоогоор 15.5 мянган иргэн даатгуулагчид хүрч хандалт авсан байна. Болзолт уралдааны удирдамжийн хүрээнд дээрх ажлуудыг зохион байгуулан хэрэгжилтийн тайланг тогтоосон хугацаанд нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн.	
4	Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын тушаал 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/83 дугаар тушаал Маягтын загвар батлах тухай 2024/05/28 05/1101	Харилцагч арилжааны банкнуудтай хамтран ажиллах гэрээг албан хаагчдад танилцуулсан. Нийгмийн даатгалын ерөнхий хуульд орсон өөрчлөлт, гэрээний дагуу арилжааны банктай хамтран ажиллаж давхардсан тоогоор 192 байгууллагын 1252.1 сая төгрөгт дансны хаалт хийж 1113.2 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг төлж барагдуулсан.	
5	Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын тушаал 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/94 дугаар тушаал Аудит акт, албан шаардлага, зөвлөмж хэрэгжүүлэх тухай 2024/06/03 05/1146	Аудитын явцад үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд үлдэгдлийг 1.5 сая төгрөгөөр илүү илэрхийлсэн алдааг залруулсан. Мөн аудитаар нийт 26.0 сая төгрөгийн албан шаардлага, 0.3 сая төгрөгийн актын төлбөр зөрчил илэрснийг 100 хувь барагдуулан Хэнтий аймаг дахь Төрийн Аудитын газар, НДЕГ-т хугацаанд нь хүргүүлсэн	
6	Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын тушаал 2024 оны 01 дугаар сарын 04-ний өдрийн А/02 дугаар тушаал Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хуваарь батлах тухай	2024 онд нийгмийн даатгалын сангийн орлого 58793,5 сая төгрөг, зарлагын гүйцэтгэл 126253,6 сая төгрөгөөр тус тус төсвийн хуваарь батлагдсанаас сангийн орлого 58898,9 сая төгрөг буюу 100,2 хувийн гүйцэтгэлтэй, зарлага 126253,6 сая төгрөг буюу 100 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.	
7	Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын тушаал 2024 оны 01 дугаар сарын 04-ний өдрийн А/03 дугаар тушаал Нийгмийн даатгалын зардлын 2024 оны төсвийн хуваарь батлах тухай	Байгууллагын үйл ажиллагааны зардалд 1548.82 сая төгрөг батлагдсанаас цалин хөлсөнд 1103.15 сая төгрөг, НДШ-д 139.40 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 43.46 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 16.84 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 5.89 сая төгрөгийг, эдийн засгийн ангилал зориулалтын дагуу батлагдсан төсвийн хүрээнд зарцуулан ажилласан.	
8	Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын тушаал 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн А/124 дугаар тушаал Төлөвлөгөө батлах тухай 2024/06/26 02/1431	Ажилтан, албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр нийт 5 сургалтад давхардсан тоогоор 120 албан хаагчдыг хамруулсан. - “Төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр” цахим сургалтад 2024-03-07нд газрын нийт 25 албан хаагч хамрагдлаа. - Аймгийн Прокурорын газартай хамтран “Гэмт хэрэг зөрчлийн ялгаа”, “Иргэний хэрэгт прокурорын оролцоо” сэдэвт сургалтыг	

		<p>Хэнтий аймгийн Прокурорын газар ахлах прокурор Б.Бямбасүрэн 18 албан хаагч хамрагдсан</p> <ul style="list-style-type: none"> - “Авлигын шалтгаан, хор хөнөөл, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр комиссар Р.Төрбулаг, “Авлигын гэмт хэрэг, түүний ойлголт” сэдвээр 2024-10-18нд 28 албан хаагч хамрагдсан - “Хориглолт, хязгаарлалт” сэдвээр АЗДТГ-н ТЗУХэлтсийн ахлах мэргэжилтэн Н.Тэмүүжин 2024-10-24нд 34 албан хаагч хамрагдсан. - Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Авлигын эсрэг өдөр”-ийг тохиолдуулан зохион байгуулсан соён гэгээрүүлэх өдөрлөгийн арга хэмжээнд 2024-12-10нд 15 албан хаагч хамруулсан. <p>Одоогийн байдлаар авлига, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон албан хаагч байхгүй болно.</p>	
9	<p>Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын тушаал 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн А/138 дугаар тушаал Төлөвлөгөө батлах тухай 2024/08/05 01/1649</p>	<p>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, ажилтнуудын сахилга хариуцлагыг сайжруулах 01 албан даалгаврын төлөвлөгөөний дагуу 8 ажлыг зохион байгуулан хэрэгжилтийн биелэлтийг хугацаанд нь Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн.</p>	
10	<p>Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын тушаал 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн А/137 дугаар тушаал Ажил зохион байгуулах тухай 2024/08/06 07/1665</p>	<p>Нийгмийн даатгалын сангийн 2024 оны 2-р улирлын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Засгийн газрын нэгтгэл Э-тайланд оруулж баталгаажуулсан. Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлж оны эхний үлдэгдлийг программд оруулсан. Мөн программын нэвтрэлттэй холбоотой байцаагч нарын ээлжийн амралтыг хойшлуулж ажиллуулсан.</p>	
11	<p>Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын тушаал 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн А/107 дугаар тушаал Журам батлах тухай 2024/08/07 07/1672</p>	<p>НДЕГ-н тушаалыг газрын болон сумдын байцаагч нарт танилцуулж хүргүүлэн ажилласан.Тайлант хугацаанд тушаалтай холбоотой илүү төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олголт хийгдээгүй байна.</p>	
12	<p>Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын тушаал 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн А/139 дугаар тушаал Ажлын цаг ашиглалт, бүтээмж, хариуцлагыг сайжруулах тухай 2024/08/14 03/1697</p>	<p>Нийгмийн даатгалын газрын албан хаагчдын болон сумдын нийгмийн даатгалын байцаагчдын ажлын цаг ашиглалтад тогтмол хяналт тавьж, цалинг тооцон олгож байна. Албан хаагчид цагийн бүртгэлээ цахим болон цаасаар хэлбэрээр өгдөг. Сумдын байцаагч нар ERP цахим систем ашиглан цагаа бүртгүүлдэг бөгөөд сарын эцэст хэвлэмэл байдлаар ирүүлдэг. Мөн газрын үйлчилгээний танхим нь дуу дүрсний өндөр нягтаршилтай хяналтын камертай байдаг. Дотоод журамд заасны дагуу 3 хүртэлх хоногийн чөлөөг хэлтсийн дарга түүнээс дээш хоногийн чөлөөг газрын даргаас авч тушаалаар баталгаажуулан ажиллаж байна.</p>	

13	<p>Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын тушаал 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/162 дугаар тушаал Аян зохион байгуулах тухай 2024/09/27 06/2006</p>	<p>Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага барагдуулах ажлын төлөвлөгөөг гаргаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөг газрын байцаагчдад танилцуулж, сумдын байцаагч нарт албан тоотоор хүргүүлж биелэлтийг тухай бүр авч, хяналт тавин ажиллаж байна. 2024 онд нийгмийн даатгалын сангуудад 51721.4 сая төгрөг төвлөрүүлэхээс 54810.5 сая төгрөг төвлөрүүлж, сангийн орлогын төлөвлөгөөг 106 хувиар давуулан биелүүллээ. Нийгмийн даатгалын шимтгэлийн оны эхний хуримтлагдсан авлагын судалгааг хуучин ашиглаж байсан программаас гаргаж, сум бүрээр хүргэж авлагыг барагдуулах чиглэл хүргүүлж ажилласнаар оны эхний авлага 2980.7 сая төгрөгөөс 2823.6 сая төгрөг буюу 96 хувийг барагдуулаад байна. Мөн Нийгмийн даатгалын ерөнхий хууль, анхаарах асуудалд сэдвээр сургалтыг ажил олгогчдын дарга, захирал, нягтлан бодогчдод хийж давхардсан тоогоор 182 байгууллагыг хамруулсан. Газрын албан хаагчдыг чадавжуулах танхимын сургалтыг 2024 оны 11 дүгээр сард зохион байгуулсан. Тус сургалтаар нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, сангийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж, өр авлага барагдуулах чиглэл өгч ажилласан. Мөн авлага бууруулах чиглэлээр 3 удаа албан бичгээр сумдад чиглэл өгч ажилласнаар 2024 онд шинээр үүссэн 3030.1 сая төгрөгийн авлагаас 1782.1 сая төгрөгийн авлагыг барагдуулаад байна.</p>	
14	<p>Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын тушаал 2024 оны 11 дугаар сарын 05-ны өдрийн А/194 дугаар тушаал Мэргэшсэн эрхийн нэмэгдэл олгох тухай 2024/11/07 03/2318</p>	<p>Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газрын Санхүү бүртгэл орлого, бүрдүүлэлтийн хэлтсийн дарга мэргэшсэн нягтлан бодогчийн хугацаагүй эрхтэй тул үндсэн цалинг 2024.11.01-ний өдрөөс нэмэгдүүлэн тооцож олгосон.</p>	
15	<p>Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын тушаал 2024 оны 11 дугаар сарын 29-ны өдрийн А/217 дугаар тушаал Сургалт зохион байгуулах, төсвийн нарийвчилсан хуваарь батлах тухай 2024/11/29 01/2472</p>	<p>ҮОМШӨ-ний сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийг сурталчлах, урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулахаар төлөвлөсөн боловч тайлант хугацаанд сургалт зохион байгуулах санхүүжилт байгууллагын дансанд орж ирээгүй байна.</p>	

ХЭНТИЙ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР

